



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 11 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 59 дүгээр
цэцэрлэгийн данс бүртгэлд
хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 14,114,430.46 /арван дөрвөн сая нэг зуун арван дөрвөн мянга дөрвөн зуун гучин төгрөг дөчин зургаан мөнгө/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Хан-Уул дүүргийн 59 дүгээр сургууль /Р.Энхбаяр/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 59 дүгээр сургууль /Р.Энхбаяр/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2020 оны 02 дугаар
сарын 11 өдрийн 0128 тоот тушаалын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Хан-Уул дүүргийн 59 дүгээр сургууль

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглаланд орсон огноо	Цанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Багшийн сандал	M-11	Хар төмөр сандал	2019	шинэ	ш	1	201,840	201,840	ДЗОУБ "Орон нутгийн хүүхэд хамгаалал"	Хандив
2	Багшийн ширээ	M-14	Шаргал өнгөтэй ширээ	2019	шинэ	ш	1	260,130	260,130		
3	Сургалтын сандал	D-13	Хар төмрөн хөлтэй	2019	шинэ	ш	20	44,370	887,400		
4	Сургалтын ширээ	D-16	Хар төмрөн хөлтэй шаргал ширээ	2019	шинэ	ш	10	101,790	1,017,900		
5	Компьютер ширээ	E-10	Хүрэн ДСП	2019	шинэ	ш	5	100,000	500,000	Эцэг эх багш ажилчид	Хандив
6	Сандал	E-12	Хүрэн ДСП	2019	шинэ	ш	10	50,000	500,000		
Тавилга эд хогшлын дүн							47	3,367,270			
7	Проектор	Epson EB 107	Epson iProjection 2 x HDMI холболт (1 x MHL)	2019	шинэ	ш	1	1,531,260	1,531,260	ДЗОУБ "Орон нутгийн хүүхэд хамгаалал"	Төсөл
8	Проекторын дэлгэц	S-1M	240*175	2019	шинэ	ш	1	215,900.46	215,900.46		
Тоног төхөөрөмжийн дүн							2	1,747,160.46			
9	Сургуулийн автобус граж	Блок	8*4*2.70 саарал	2019	шинэ	ш	1	5,500,000	5,500,000	Эцэг эх багш ажилчид	Хандив
10	Уурын зуухны нүүрсний пин	Блок 5*3*2.50	5*3*2.50 1-р хичээлийн байр	2019	шинэ	ш	1	3,500,000	3,500,000		
Бусад үндсэн хөрөнгийн дүн							2	9,000,000			
Нийт хөрөнгийн дүн							51	14,114,430.46			